

2022 ОНЫ “ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС”-ЫН ДЭГЛЭМ

САХИУЛАХ АЖЛЫН ТАЙЛАН

2022.05.20

НЭГ. ЗОРИЛГО

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйл “Шугам сүлжээний хамгаалалтын зурвас” заалтын хэрэгжилтийг хангуулах, зөвлөмж өгөх, албан шаардлага тараах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

ХОЁР. ШАЛГАЛТ ЯВУУЛСАН БАЙДАЛ

Компанийн тэргүүн дэд захирал бөгөөд ерөнхий инженерийн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр баталсан “ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС”-ын дэглэм сахиулах аяны ажлын удирдамжийг батлуулан “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн хэмжээнд 2021 оны 03 дугаар сарын 14-нөөс 05 дугаар сарын 16-ны хооронд Улаанбаатар, Зүүн-өмнөд бүс, Говийн бүс, Төвийн бүс, Хангайн бүсийн салбарыг хамруулан ажлуудыг хийж гүйцэтгэв.

<p style="text-align: center;">БАТЛАВ ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.ДАШДАВАА</p> <p style="text-align: center;">2022 оны 03 дугаар сарын 09</p> <p>“ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС”-ЫН ДЭГЛЭМ САХИУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ Нэг. Зорилго</p> <p>Монгол улсын “Эрчим хүчний тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дүгээр залт, Засгийн газрын 2001 оны 283 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах, осол аваарис урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажилд хяналт тавьж мөрдүүлэх, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамгаалалтын зурвасын зөрчлийг арилгах, мэдээллийн сан бүрдүүлэх хүн ам, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах</p> <p style="text-align: center;">Хоёр. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн</p> <p>Хяналт мониторингийн хэлтсийн дарга, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Я.Мөнхтөр, Хяналт мониторингийн хэлтсийн ахлах бөгөөд Техник хяналтын инженер Д.Мөнхзаяа, Хяналт мониторингийн хэлтсийн Техник хяналтын инженер Н.Эрдэнэжаргал, Улаанбаатар, Төв, Хангай, Зүүн-Өмнөд, Говийн бүсийн салбаруудын Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн инженер, техник хяналтын инженер, дотоод хяналтын ажилтан болон Засварын албаны инженер техникийн ажилтан, монтёрууд</p> <p>Гурав. Хамрах хүрээ</p> <p>220, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын “Хамгаалалтын зурвас”-ын дэглэмийг зөрсөн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад</p> <p style="text-align: center;">Дөрөв. Хугацаа</p> <p>“Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 05 дугаар сарын 16-ны хооронд явуулна.</p> <p style="text-align: center;">1</p>	<p style="text-align: center;">Тав. Зохион байгуулан явуулах ажлын чиглэл</p> <p>5.1 Өндөр хүчдэлийн дэд станц, цахилгаан дамжуулах агаарын шугамуудын трассын дагуу “Хамгаалалтын зурвас”-ын дэглэмийг зөрчиж үйл ажиллагаа явуулж, амьдрал сууж байгаа айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудад Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн албан шаардлага өгөх, салбарын мэдэгдэх хуудас тараах, шаардлагатай тохиолдолд торгууль ноогдуулах, эрчим хүчээр хязгаарлах</p> <p>5.2 “Хамгаалалтын зурвас” газрыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх, албан шаардлага өгөх зэрэг ажлуудыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нийслэл, дүүргийн газрын албатай хамтран ажиллах</p> <p>5.3 Нийслэл, хот, аймаг, сум дүүргийн газрын албанд албан бичгээр зөрчлийн талаар мэдэгдэл хүргүүлэх, биелэлтэд хяналт тавих</p> <p>ХЯНАСАН: ХМХ-ИЙН ДАРГА <i>Я.Мөнхтөр</i> Я.МӨНХТӨР 2022.05.09</p> <p>БОЛОВСРУУЛСАН: ХМХ-ИЙН АХЛАХ БӨГӨӨД ТЕХНИК ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР <i>Д.Мөнхзаяа</i> Д.МӨНХЗАЯА</p> <p>ХМХ-ИЙН ТЕХНИК ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР <i>Н.Эрдэнэжаргал</i> Н.ЭРДЭНЭЖАРГАЛ</p> <p style="text-align: center;">2</p>
--	---

Хамгаалалтын зурвасын удирдамж

ГУРАВ. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Хамгаалалтын зурвас зөрчилтэй ААН, айл өрхүүдэд учирч болох аюул эрсдэл, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн талаар сурталчилгаа хийх, хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэх, эрчим хүчний найдвартай ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлж сургалт үйл ажиллагааг зохион байгуулж нийт давхардсан тоогоор **600** гаруй иргэн, ААН-д урьдчилан сэргийлэх мэдээлэл хийж, таниулах материалыг тараан ажиллаа. Үүнд:

Улаанбаатар салбарт 220 кВ-ын 211, 212-р агаарын шугамын тулгуур №45-46 хооронд хамгаалалтын зурваст зөрчилтэй Mongolian car market ХХК-ийн 28 инженер техникийн ажилтнуудад сургалт зааварчилгаа өгсөн.

ЦДҮС ТӨХК-ийн 2022 оны Хамгаалалтын зурваст дэглэм сахиулах аяны хүрээнд Баянгол дүүргийн 20-р хороо Гурвалжингийн гүүрний урд хэсэг 16 машин механизм, “ДЦС-4” ТӨХК-ийн замын урд хэсэгт 12 машин механизм нийт 50 гаруй жолооч нарт сургалт зохион байгуулах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр амжилттай явуулсан.

Сургалтын үеэр машин механизмын жолооч, экскаваторын оператор нарт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын аюул эрсдэлийн талаар сурталчлах, яаж урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгч Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн заалт бүхий гарын авлага тараасан.

Сургалтыг Төв компанийн ХМХ-ийн ахлах Мөнхзаяа, ХАБЭАИ Б.Батчулуун, УБ салбарын ХАБЭА хяналтын ахлах инженер М.Ууганбаяр, ТХИ Б.Сонор нар зохион байгуулж 2022.04.07-ны 01/282 БГД дэх цагдаагийн албанд хүргүүлсэн албан бичгийн дагуу тус албаны Ахлах дэслэгч Батмөнх жолооч операторуудыг идэвхтэй хамруулахад дэмжлэг үзүүлсэн.




Хангайн бүсийн салбарт 110кВ-н Хялганат-А,Б шугамын хамгаалалтын зурваст орсон 6 айл өрх, Булган-Мөрөнгийн ЦДАШ-ын №19-20, Булган-Хархоринын ЦДАШ-ын тулгуур №79-80, 110/35/10кВ-ын Цэцэрлэг дэд станцын болон 110 кВ-ын №405-407 дугаар тулгуурын хооронд хамгаалалтын зурвас зөрчсөн тус бүр 22 айл, өрх, 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станцын хамгаалалтын зурвастай ойролцоо байрласан 21 айл, өрхийн хүмүүс, ААН-үүдэд урьдчилан сэргийлэх мэдээлэл хийж, таниулах материалыг тараасан.

Хөвсгөл аймгийн Хөвсгөлийн өнгө цахим телевиз, Өвөрхангай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний улсын байцаагч О.Төмөрчөдөрөөр дамжуулан Өвөрхангай аймгийн МХГ-ын раге хуудаст байршуулсан Булган, Хишиг-Өндөр, Баянхонгор, Өвөрхангай дэд станцын 41 ажилтнууд өөрийн Facebook хуудсанд эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дэглэмийн тухай ЦДҮС ТӨХК-иас бэлтгэн гаргасан видео бичлэгийг байршуулахад 9300 хүн үзэж 601 хүн share хийсэн.



Зүүн-Өмнөд бүсийн салбарт ажлын хэсэг 2022 оны 03-р сарын 27-ноос 04-р сарын 12-ны өдрүүдэд 220/110 кВ цахилгаан дамжуулах агаарын шугамуудад ээлжит үзлэгийн нийт уртын дагуу хийж, хамгаалалтын зурваст үйл ажиллагаа явуулж байгаа 5 аж ахуйн нэгж, 1 хувь хүнд мэдэгдэл өгч, хамгаалалтын зурваст үйл ажиллагаа явуулахад үүсч болох эрсдлийг тайлбарлан таниулах ажил хийсэн.

“Хүчдэлтэй гүйдэл дамжуулах хэсэгт ойртох зай хэмжээ болон цахилгаан тоног төхөөрөмжийн хамгаалалтын зурвас”-н тухай видео болон зурган файлыг Зүүн-Өмнөд бүсийн салбарын сургалтын телеграмм группд байршуулан 188 ажилтанд танилцуулсан байна.



ДӨРӨВ. ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСТ АЛБАН МЭДЭГДЭЛ, УЛСЫН БАЙЦААГЧИЙН АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ

220, 110, 35 кВ-ын ЦДАШ, дэд станцын хамгаалалтын зурвас зөрчилтэй ААН, айл өрхүүдэд учирч болох аюул эрсдэл, Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн талаар сурталчилгаа хийх, хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгө эрсдэх, эрчим хүчний найдвартай ажиллагаа алдагдахаас урьдчилан сэргийлж, албан мэдэгдэл хүргүүлэх төлөвлөгөө гаргаж бэлтгэл ажлын хүрээнд **1229** албан мэдэгдэл, 30 гаруй албан шаардлага тарааж, аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхааруулга өгч ажилласан.

Улаанбаатар салбарт Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар, Налайх дүүргүүд болон Төв аймгийн Баянчандмань сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй 220 кВ-ын 4, 110 кВ-ын 18, 35 кВ-ын 2 цахилгаан дамжуулах агаарын шугамын трассын дагуу **1126** ширхэг /ААН 260, Айл өрх 866/ дэд станцын хамгаалалтын зурваст **51** ширхэг /ААН 8, Айл өрх 43/ нийт **1177** албан мэдэгдэл хүргүүлсэн байна.

Зүүн-Өмнөд бүсийн салбарт 2021 онд Говьсүмбэр аймагт шинээр 32 айлын газар олгогдож зөрчил 8 болсон. 2022 оны байдлаар бүртгэлтэй байсан зөрчлөөс 3-г арилгуулж, 2 зөрчил /ААН 1, Айл өрх 1/ шинээр бүртгэгдсэн. Өнөөдрийн байдлаар /ААН 4, Айл өрх 32/ газар олгосон зөрчил бүртгэлтэй, улсын байцаагчийн албан шаардлага өгч ажилласан.

Төвийн бүсийн салбарт Сэлэнгэ, Дархан, Төв аймгийн хамгаалалтын зөрчилтэй 34 айл өрхөд мэдэгдэх хуудас, Дархан-Уул аймгийн 15 айлд газрын албаны албан шаардлага, Сэлэнгэ аймгийн 3 ААН-д Улсын байцаагчийн албан шаардлагыг тус бүр биечлэн эзэмшигч бүрд өгсөн. Эзэнгүй байсан 4 айл өрхийн мэдэгдлийг багын даргад хүлээлгэн өгч ажилласан байна.



Эрчим хүчний улсын байцаагчтай хамтран ЦДАШ, дэд станцын хамгаалалтын зурваст зөрчилтэй **28** аж ахуй нэгжид Эрчим хүчний улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж ажилласан.

№	Зөрчилтэй ААН	Зураг
1	АШ 111, 112-ын тулгуур №6-7 хооронд хамгаалалтын зурваст АРИНА КОМПЬЮТЕРС ХХК гагнуур ажиллуулж буй зөрчилтэй. Албан шаардлагыг захирал Б.Бат Оршиход өгсөн.	
2	Цэвэрлэх дэд станцын хамгаалалтын зурваст ЭВСЭГ ЭРЧ ХҮЧ ХХК төмрийн худалдаа эрхэлдэг зөрчилтэй. Албан шаардлагыг засвар хариуцсан ажилтан Т.Лхамасүрэнд өгсөн.	
3	АШ 118-ын тулгуур №7-8 хооронд хамгаалалтын зурваст иргэн н.Гончиг гагнуур ажиллуулж буй зөрчилтэй.	
4	АШ 105, 106-ын тулгуур №17-18 хамгаалалтын зурваст НЬЮ БУРБЕРИ ХХК цамхагт кран ажиллуулж буй зөрчилтэй. Албан шаардлагыг төслийн удирдагч Б.Хорлоод хүргэсэн.	
5	"Чойр Ложистик Сервис" ХХК-д эрчим хүчний улсын хяналтын байцаагч Я.Мөнхтөрийн 2022.04.29-ний өдрийн 60-07-010/№1 албан шаардлагыг "Сайн сайхан консалтинг сервис" ХХК-ийн захирал Н.Сайнгэрэлд өгсөн..	

6	<p>АШ 109, 110 тулгуур №14-15 хамгаалалтын зурваст ВИСИ ХХК контейнер хураасан зөрчилтэй. Албан шаардлагыг үйлдвэрийн дарга Хятадын иргэнд өгсөн.</p>	
7	<p>АШ 101, 102-ын тулгуур №27-28 хооронд хамгаалалтын зурваст НЬЮ СЕВЕР ХХК шороо асгасан зөрчилтэй. Албан шаардлагыг ээлжийн дарга Л.Чулуунболдод өгсөн.</p>	
8	<p>110/35/10кВ-ын Арвайхээр дэд станцын хувьд 5 сарын 12-ны өдөр Т№429-434 хооронд байрласан 4 айлуудад улсын байцаагчийн албан шаардлагыг хүлээлгэн өгсөн. 110 кВ-ын Хархорин-Арвайхээр ЦДАШ-ын доор</p>	
9	<p>110 кВ-ын Мөрөн-Тэлмэн ЦДАШ-ын доор. Шинэмөрөн ОНӨХК-н Хөвсгөл АЗЗА ХХК-д /захирал Ц.Нацагдорж Худалдаа үйлчилгээний төвийн барилга, автозогсоол / Т№01-02, Авто худалдааны төвд /Хувийн компанийн хашаа/ Т№02-03, Шинэс мод түлшний худалдааны төвд /захирал Б.Халтар Хувийн хашаа/ Т№02-03, Иргэн Б.Мөнхсайханд /худаг УДДТ-11 хувийн / Т№03-04</p>	
10	<p>Сэлэнгэ аймагт “Саруул номгон”, “Түмний хишиг”, “Шивээ булаг” гэсэн ААН-дэд зөрчилтэй ба улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.</p>	







ТАВ. ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР ААН-Д ЗӨВЛӨМЖ ӨГӨХ ЧИГЛЭЛЭЭР

Эрчим хүчний шугам сүлжээний найдвартай ажиллагааг хангах 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 01/475 тоот гүйцэтгэх захирлын албан бичиг, 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Улаанбаатар салбарын даргын 01/371 тоот зөвлөмжийг ЦДАШ-ын хийц хэсэгт ахуйн болон сав баглаа боодлын хаягдал гялгар уут хог салхинд хийсэж тохогдож байгаатай холбоотой аж ахуй нэгжүүдэд “Хог хаягдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлэн хүний хүчин зүйлээс шалтгаалсан аливаа тасралт, саатал гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор өөрийн эзэмшлийн хашаанд байгаа хог хаягдлыг цэвэрлэх, бараа материалыг салхинд хийсгэхгүй байх, ил задгай хог хаягдлыг хаяхгүй байхад анхааруулж ХУД-ийн 3-р хороо, БГД-ийн 20-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг хувь хүн албан байгууллагуудад хүргүүлж ажилласан.

<p> ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ Чингисийн өргөн чөлөө 22/1, 3 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17060 Утас: 7004 2939 И-мэйл: info@transco.mn, Ba@сай: www.transco.mn</p> <p>2022.05.20 № 01/475 Танай _____-ны № _____-т</p> <p><input type="checkbox"/> Зохион байгуулалтын арга хэмжээний талаар хамтран ажиллах тухай</p> <p>Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн 70 хувийг эзэлсэн аймаг, хот, сум суурин газрын хэрэглэгчдэд 220, 110 кВ-ын өндөр хүчдэлийн дэд стэнц, агаарын шугамавар цахилгаан эрчим хүчийг тасралтгүй дамжуулж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байгаа төрийн өмчит компани юм.</p> <p>Манай орны нийт нутгаар жил бүрийн 3 дугаар сараас 6 дугаар сарын хооронд байгаль цаг уурын хувьд огцом өөрчлөлттэй салхины хурд 6-34 м/с хүрсэн тухай Цаг уур эрдэм шинжилгээний хүрээлэнгийн олон жилийн судалгаа байдаг.</p> <p>Нийслэлийн Хан-Уул, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт байрлах малын түүхий эд арьс шир агуулах, боловсруулах, бетон цемент, төмрийн худалдаа, хүнд машин механизмын засварын төв, хөдөө орон нутгийн ачаа тээврийн чиглэлээр үйлдвэр аж ахуйн нэгжүүд төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг бүс юм.</p> <p>Эдгээр үйлдвэр аж ахуйн нэгжүүдийн технологи үйл ажиллагааны бараа материалын сав, баглаа боодол, ахуй хэрэглээний хог хаягдлыг агаарын шугамын доор барилгын болон үйлдвэрлэлийн хог хаягдал асгаснаас салхинд хийсэж, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур, дамжуулагч утсанд тохогдон тасралт, саатал гарах, дэд станцын хашавны ойролцоо агаарын шугамын тулгуурын доор түймэр гарах зэрэг зөрчлүүд буурахгүй нэмэгдсээр байна.</p> <p>Тухайлбал, 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр 110 кВ-ын “Дундгол” цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур №29-д барилгын мөнгөлөг гадаргуутай шилэн хөвөн тохогдсоны улмаас төвийн бүсийн эрчим хүчний системийн хэмжээнд аваар гарч нийслэл бүрэн хүчдэлгүй болсон тохиолдол гарч байсан.</p> <p>Иймд хаврын улирал эхэлж, салхи шуурга, хуурайшилт ихтэй байгаа тул байгалийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалсан аливаа тасралт, саатал гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн харьяа дүүргүүдийн хэмжээнд холбогдох байгууллагуудаар дамжуулан айл өрх, үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлын хадгалалт, тэвэрлэлтэд хяналт тавих чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч хамтарч ажиллахыг хүсье.</p> <p>17 220 2000317</p>	<p>2</p> <p>220, 110, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур, дамжуулагч утсанд тохогдсон сүүлийн 2 жилийн товч судалгааг хавсралтаар хүргүүлж байна.</p> <p>Хавсралт №. хуудастай</p> <p> ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ <i>Р.Я.М</i> Б.НЯМСАМБУУ</p> <p>D:\alban hereg hotol_2022 on\A\3 ear\02_03_00_1 docx</p>
<p>Нийслэлийн ЗДТГ, НМХГ-т явуулсан албан бичиг</p>	

1	<p>Иргэн Ш.Амбек : Зөвлөмжийг харуул П.Өлзийсайханд танилцуулсан ХУД-ийн 3-р хороонд контейнерын худалдаа эрхэлдэг хувь хүн.</p>	
2	<p>БАТЖИХ ХАН ХХК: Зөвлөмжийг захирал Б.Батсайханд танилцуулсан ХУД-ийн 3-р хороонд барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанийн АА-н хашаа</p>	
3	<p>БГД-ийн журмын хашаа: Зөвлөмжийг манаач Э.Уранжаргалд танилцуулсан ХУД-ийн 3-р хороо журамлагдсан ТҮЦ буюу худалдаа явуулдаг жижиг сууц хадгалах хашаа</p>	
4	<p>Тэнүүн Өлзий ХХК: Зөвлөмжийг ерөнхий инженер П.Бямбабаярт танилцуулсан ХУД-ийн 3-р хороонд төмрийн худалдаа эрхэлдэг байгууллага.</p>	
5	<p>Монгол самик ХХК: Зөвлөмжийг захирал Р.Цэрэндолгор танилцуулсан БГД-ийн 20-р хороонд барилгын материалын худалдаа эрхэлдэг байгууллага.</p>	
6	<p>Toyotires ХХК: Зөвлөмжийг менежер Ц.Хүрэлбаатар танилцуулсан БГД-ийн 20-р хороонд барилгын материалын худалдаа эрхэлдэг байгууллага.</p>	

7	<p>АУМ АЛТ ХХК: Зөвлөмжийг менежер С.Бат Эрдэнэ танилцуулсан БГД-ийн 20-р хороонд уул уурхайн хүнд машин механизмын засварын төв</p>	
8	<p>УБЗЗАГ: Улаанбаатар зам засварын ашиглалтын газар зөвлөмжийг диспетчер Ш.Алтанд танилцуулсан БГД-ийн 20-р хороонд</p>	
9	<p>Тавантолгой түлш ХХК: Зөвлөмжийг ХАБЭА-н инженер Г.Лхагвадоржид танилцуулсан СХД-ийн 20-р хороонд утаагүй түлшний баруун бүсийн үйлдвэр</p>	
10	<p>Нийслэлийн замын хөгжлийн газар: Зөвлөмжийг менежер С.Түмэндэмбэрэл танилцуулсан БГД-ийн 20-р хороонд замын материалын лаборатори</p>	
11	<p>Монгол битум индустрал ХХК: Зөвлөмжийг менежер Б.Энхсайханд танилцуулсан БГД-ийн 20-р хороонд замын битумын үйлдвэр</p>	
12	<p>Экстир ХХК: Зөвлөмжийг нягтлан А.Золжаргал танилцуулсан СХД-ийн 20-р хороонд хүнд машин механизмын засварын төв</p>	

13	<p>Иргэн Э.Даваажав: Зөвлөмжийг Иргэн Э.Даваажавд танилцуулсан СХД-ийн 20-р хороонд хүнд машин механизмын засварын төв</p>	
14	<p>Хишиг арвин индистрал: Зөвлөмжийг менежер Ш.Ням Осорт танилцуулсан СХД-ийн 20-р хороонд уул уурхайн хүнд машин механизмын сэлбэг хэрэгсэл засварын төв</p>	
15	<p>Чингэлтэй дүүргийн 7-р хороо: Зөвлөмжийг хорооны зохион байгуулагч С.Нямжаргалд танилцуулсан</p>	
16	<p>Чингэлтэй дүүргийн 12-р хороо: Зөвлөмжийг хорооны зохион байгуулагч Л.Болортуяа танилцуулсан.</p>	
17	<p>Баянгол дүүргийн 23-р хороо: Зөвлөмжийг хорооны зохион байгуулагч Ц.Болормаа танилцуулсан.</p>	
18	<p>Нарантуул худалдааны төв: Зөвлөмжийг зохион байгуулагч хүлээн авсан. Худалдаа үйлчилгээ зах.</p>	

ЗУРГАА. ХАМГААЛАЛТЫН ЗУРВАСЫН АРИЛГАСАН ЗӨРЧЛҮҮД



Улаанбаатар салбарын эзэмшлийн шугам тоноглол түүний хамгаалалтын бүсэд Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн хэрэгжилтийг хангах иргэн, аж ахуй нэгжийг дагаж мөрдүүлэх хяналт шалгалт зөрчил арилгах ажлуудыг зохион байгуулж шинээр **70** хамгаалалтын зурвасын зөрчлийг илрүүлж, **47** зөрчлийг арилгуулж ЭХЯ, МХЕГ, НМХГ, ЦЕГ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгуудын МХГ зэрэг 10 гаруй байгууллагуудтай хамтарч ажилласан.

1. БЗД-ийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэр 110 кВ-ын 149, 150 дугаар агаарын шугамын Дарь Эх салбар тулгуур №10-11 хооронд 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр хамгаалалтын зурваст шороо асгасан зөрчлийн дагуу Нийслэлийн шуурхай удирдлагын төвд гомдол гаргасан СБД-ийн цагдаагийн 2 дугаар хэлтсийн ахмад Чойбалсан эзэн холбогдогчийг олж тогтоон зөрчлийг арилгуулсан.
2. Геодези усны байгууламжийн газарт 2022.03.25-ны өдөр хүргүүлсэн шаардлагын дагуу тухайн байгууллага 220 кВ-ын 205 206 дугаар агаарын шугамын тулгуур №12-13 хооронд 3-р фаз руу ойртсон 2 ширхэг улиас модыг тайрч зөрчил арилгасан.
3. Үндэсний цэцэрлэг хүрээлэнгийн ОНӨТҮГ-т 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/142 тоот албан бичгээр шаардлага хүргүүлсний дагуу цахилгаан хариуцсан ажилтан Б.Даваабаатар АШ 125, 126-ын Дүнжингарав салбар тулгуур 4-5 хооронд 5 ширхэг мод тайрах ажилд Техник хяналтын инженер Б.Сонор, ЗА-ны шугамын монтёр Б.Оргилын хяналтад аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч 12 хүний бүрэлдэхүүнтэй бригад зөрчил арилгасан.



Зөрчлийн зураг зөрчил арилгасан байдал

4. 110 кВ-ын 109, 110 дугаар агаарын шугамын тулгуур №22-23-ын хооронд хамгаалалтын зурваст Баянгол ХХК 40 тн-н 9 ширхэг 20 тн-н 3 ширхэг контейнерыг хашаан дотроо өөр тийш нь байрлуулж, хамгаалалтын зурвасыг чөлөөлөв. Шугамын доор хогыг цэвэрлэх, шугамын доор машин механизм ажиллуулахгүй байх, дахин контейнер болон төмөр болон бусад ачаа буулгахгүй байхыг Баянгол ХХК-н хүмүүст анхааруулав.
5. 110 кВ-ын 103, 104 дугаар агаарын шугамын тулгуур №24-25 хооронд Мон Кон Констракшн ХХК төмөр бэлдцийн талбай үйл ажиллагаагаа явуулж зөрчилд ажиллаж албан шаардлага өгсний дагуу талбайг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны дотор чөлөөлөхөөр болж хугацаандаа хамгаалалтын зурвасыг чөлөөлсөн.
6. 220 кВ-ын 211, 212 дугаар агаарын шугамын тулгуур №7-ын доор хог хаях, машин ачиж буулгах зорилгоор тулгуурын обломыг хийцийг өөрчилснийг цэвэрлүүлж бетон хийцийг ачуулж зөрчлийг арилгуулсан.
7. 110 кВ Багануур -Төв ЦДАШ-ын анкер №23-г тойруулж хашаа барьсан байсныг Багануур ХК-д 2022.03.24-ний өдөр 02/83 тоот албан бичиг явуулж 2022 оны 04-р сарын 19-ний өдөр анкер тойруулж барьсан хашааг буулгасан.
8. 110 кВ Чойр- Айраг 110кВ ЦДАШ-ын тулгуур №181-182-н хооронд "Мөнгөн хас шонхор" ХХК нь Уул уурхай ашиглахаар хашаа барьсан байсныг буулгаж хамгаалалтын зурвасыг чөлөөлсөн.
9. 110/10 кВ Замын-Үүд дэд станцын хамгаалалтын зурваст Төмөр авах цэг ажиллаж байгаа 110/10 кВ Замын-Үүд дэд станцын байрлаж байгаа нутаг дэвсгэр Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Сүлд багийн 12-р хэсэгт харьяалагддаг бөгөөд хамгаалалтын зурваст "Төмөр авах цэг" үйл ажиллагаа явуулж байгаа талаар сумын засаг дарга болон газрын албанд мэдэгдэж буулгах шийдвэр гаргуулан буулгасан.
10. Дархан-Уул аймагт 21 айл өрх, Сэлэнгэ аймагт 28 айл өрх, 6 ААН, Төв аймагт 6 айл өрх буюусалбарын хэмжээнд нийт 55 айл өрх, 6 ААН хамгаалалтын зөрчилтэй байсан. 2022.05.16-ний байдлаар 25 айл өрх ААН зөрчлөө устган хашаагаа татсан хэдий ч үзлэг шалгалт хийх явцад 6 айл өрх хамгаалалтын бүсэд шинээр буусан зөрчил илэрсэн.






220 кВ-ын 205, 206 дугаар агаарын шугамын тулгуур №29-30 хооронд хамгаалалтын зурваст зөрчилтэй иргэн Уранчимэг болон өмгөөлөгч Ц.Бажий нартай уулзаж Эрчим хүчний тухай хууль тогтоомж дүрэм журмыг тайлбарласан.

ДОЛОО. ЯВУУЛСАН АЛБАН БИЧИГ



Тайлангийн хугацаанд ЭХЯ, ЭХЯ, МХЕГ, НМХГ, ЦЕГ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгуудын МХГ зэрэг 10 гаруй байгууллагуудтай хамгаалалтын зурвасын зөрчил арилгах тухай давхардсан тоогоор нийт **30** гаруй албан бичгийг хүргүүлж ажиллаа.

Мөн Геодиз усны байгууламж, Хэра экуйпмент, БЗД-ийн цагдаагийн 3-р хэлтэст, Төв аймгийн Лүн суман дахь ойн анги, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн байгууллагуудад албан бичиг хүргүүлж хамгаалалтын зурвасын зөрчил арилгах, хамтран ажиллах учирч болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлж хамтран ажиллаж байна.

Салбаруудад Өвөрхангай аймгийн Хархорин сум, Булган аймгийн Хангал сум, Орхон аймгийн Баян-Өндөр сум, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгон, Төв аймгийн Баяндэлгэр сум, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн засаг дарга болон газрын албанд хамгаалалтын зурвасын зөрчилтэй ААН, айл өрхийн зөвшөөрлийг цуцлах тухай албан бичиг төлөвлөж явуулсан.

 <p>ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СУЛЖЭЭ ТӨРӨЙН АНГИТ ХУВИДАЛТ КОМПАНИ УЛААНБААТАР САЛБАР Зочин хүчнэй гудамж 26/1, Үндэсний баруун бүс, 20 дугаар хороо, Баянгол дүүрг, Улаанбаатар хот 16101 Утас: 7024 1659, факс: (976) 7024 1111 И-мэйл: info.ulaanbaatar@transco.mn, info@ulaanbaatar.transco.mn</p> <p>Улаанбаатар, 2022 оны 08 сарын 20 Танай № 01/288</p> <p>Дэмжлэг хүсэх тухай</p> <p>"Цахилгаан дамжуулах үндэсний сулжээ" ТӨХК-ийн Улаанбаатар салбар нь Улаанбаатар хотын ойр орчмын сум суурин газрыг өөрийн эзэмшлийн 1700 км өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам болон 33 дэд станцаар дамжуулан хэрэглэгчид цахилгаан эрчим хүчийг тасралтгүй дамжуулах үүрэгтэй байгууллага юм.</p> <p>Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр "ДЦС-4" ТӨХК-ийн замын урд хэсэгт байрлах төвийн эрчим хүчний систем үүсгэж байгаа онц чухал 220 кВ-ын 205, 206, 208, 110 кВ-ын 109, 110, 111, 112 дугаар агаарын шугамууд, төвийн эрчим хүчний эх үүсвэрүүдийг холбосон чухал ач холбогдол бүхий цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст хэт өндөр ачаатай том оврын машин механизм байрлах, ачаа шилжүүлж ачиж байгаа нь аварга саатлын үед транссын дагуу гамтал устгах, засвар үйлчилгээ хийх боломжгүй болох, хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугамын нөлөөлд орж хүний амь нас, эд хөрөнгө эрсдэх, эрчим хүчний найдвартай ажиллагаа алдагдах нөхцөл байдал үүсээд байна.</p> <p>Тус зөрчил нь "Эрчим хүчний тухай хууль" 33.1 дахь заалт "Эрчим хүчний шугам сулжээ хамагалах дүрэм" 3.2 дахь заалт "Хамгаалалтын зурваст эрчим хүчний шугам сулжээ, тоног төхөөрөмжийн горим, ажиллагаа алдагдуулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэсэн хууль тогтоомжийг зөрчиж байгаа тул "ЦДДС" ТӨХК-ийн Улаанбаатар салбарын ажилтнууд Баянгол дүүргийн 20-р хороо Гуравжингийн гүүрний урд хэсэг, "ДЦС-4" ТӨХК-ийн замын урд хэсэгт байрлах машин механизмын жолооч нарт сургалт үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөж байна.</p> <p>Тухайн сургалт үйл ажиллагаа танай байгууллагын дэмжлэгтэй 2018 оноос хойш жил бүр зохион байгуулж хувь хүн, албан байгууллагын ажилтнуудын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй сургалт болж байна.</p> <p>Иймд сургалт үйл ажиллагаанд өөрсдийн зүгээс холбогдох хууль дүрмийн хүрээнд дэмжлэг үзүүлж бидэнтэй хамтран ажиллана уу.</p> <p>Хавсралт 2-хуудастай</p> <p>САЛБАРЫН ДАРГА  М.МӨНХБҮРЭВ</p>	 <p>"Цахилгаан дамжуулах үндэсний сулжээ" ТӨХК-ийн Улаанбаатар салбарын 2022 оны 08 дугаар сарын 20 ны өдрийн 01/288 тоот албан бичгийн хавсралт</p> <p>Зөрчлийн зураг</p> <p>Ачаа шилжүүлж ачиж байгаа нь</p> <p>Өндөр хүчдэлийн шугамын доор зөвшөөрөлгүй машин механизм ажиллаж буй байдал</p>
---	--

Баянгол дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр "ДЦС-4" ТӨХК-ийн замын урд хэсэгт байрлах 220 кВ-ын 205, 206, 208, 110 кВ-ын 109, 110, 111, 112 дугаар агаарын шугамуудын хамгаалалтын зурваст байрлаж буй том оврын машин механизмын жолооч нарт сургалт зохион байгуулах ажлын хүрээнд БГД дахь замын цагдаагийн хэлтэст албан бичиг хүргүүлсэн.

<div style="text-align: center;">  <p>НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЛБАНД</p> </div> <div style="text-align: center;"> <p>ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ</p> <p>Чингэлтэй өргөн чөлөө 22/1, 3 дугаар хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17066 Утас: 7334 2939 И-мэйл: info@transco.mn, Вэбсайт: www.transco.mn</p> <p>2022.04.20 № 01/641 танай _____-ны № _____-т</p> <p>Дэмжлэг хүсэх тухай</p> </div> <p>Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот болон 18 аймаг, 260 гаруй сум, суурин газрын нутаг дэвсгэрт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын ашиглалт, засвар үйлчилгээ, аюулгүй байдлыг хариуцан цахилгаан эрчим хүчийг тасралтгүй, найдвартай дамжуулах үйл ажиллагаа явуулдаг 100 хувь төрийн өмчит хувьцаат компани юм.</p> <p>Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийн нутаг дэвсгэрт Эрчим хүчний тухай хууль, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажсан 220000,110000 Вольтын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурвас газарт хүний амь нас, эрүүл мэндэд өндөр аюул эрсдэлтэй нөхцөлд 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн байдлаар 955 гаруй айл өрх, аж ахуйн нэгжүүд газрыг өмчлөх болон зээмшиж үйл ажиллагаа явуулж, амьдрал сууж байна.</p> <p>Дэд станцууд болон 220, 110, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст аж ахуйн нэгжүүд зөвшөөрөлгүй байнгын үйл ажиллагаа явуулах, айл өрхүүд суурьшиж байгаа нь "Эрчим хүчний тухай хууль"-ийн 33.1 дүгээр зүйл, "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн 2.7 дугаар заалтуудыг зөрчиж байна. "Эрчим хүчний тухай хууль", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-д зааснаар 220 кВ-ын шугамд захын утаснаас 2 тийш 6 метр, 110 кВ-ын шугамд захын утаснаас 2 тийш 5 метр, 35 кВ-ын шугамд захын утаснаас 2 тийш 4 метр зайд удаан хугацаанд оршин суух, бүх төрлийн үйл ажиллагааг явуулахыг хориглосон байдаг.</p> <p>Тус компанийн зүгээс цахилгааны аюул эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эдгээр айл өрх, аж ахуйн нэгжүүдэд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг мэдээлэл тогтмол явуулах, жил бүр хамгаалалтын зурвас чөлөөлөх албан шаардлага өгөх, эрсдэл өндөртэй цэгүүдэд анхааруулах самбарууд байршуулах зэрэг ажлуудыг шат дараалалтай зохион байгуулж байгаа хэдий ч зөрчлүүд буурахгүй нэмэгдсээр байна.</p> <p>Нийслэл, дүүргээс газар олгох, хашаа барих, төмрийн зах ажиллуулах, элс хайрга зарах цэг байрлуулах, барилгын хог хаягдал, шороо хаях, өргөх зөөх болон том оврын машин механизмуудын зогсоол болгон ашиглах гэх мэт нийтлэг зөрчлүүд нь цахилгаан дамжуулах агаарын шугамын аюулгүй байдлыг алдагдуулж, нийтийг хамарсан аввар, осол гарах, "0" зогсолт хийх нөхцөл үүсгэж өндөр эрсдэлтэй байн.</p> <p style="text-align: right;">172203000452</p>	<div style="text-align: center;">2</div> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамгаалалтын зурвасыг чөлөөлүүлэх талаар 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/1040 дугаар албан бичгийг хавсралтын хамт хүргүүлж байсан.</p> <p>Иймд "Эрчим хүчний тухай хууль", "Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм"-ийн холбогдох заалт, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст зайлшгүй шаардлагатай айл өрх, аж ахуйн нэгжүүдэд газар олгосон зөвшөөрлийг цуцлах, олгосон газрыг өргөтгөн хашаа, барилга барьсан зөрчлийг арилгаж, хамгаалалтын зурвасыг бүрэн чөлөөлөх ажилд туслалцаа үзүүлэхийг хүсье.</p> <p>Өндөр хүчдэлийн агаарын шугамын хамгаалалтын зурвасаас нүүлгэн шилжүүлэх шаардлагатай айл өрх, аж ахуйн нэгжүүдийн судалгааг хавсралтаар хүргүүлэв.</p> <p>Хавсралт 6, хуудаастай.</p> <div style="text-align: center;">  <p>ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ <i>Дам</i> Б.НЯМСАМБУУ</p> </div> <p style="text-align: right; font-size: small;">D:\alban hereg hotol_2022 on\4\4 sар\02_04_20_2.docx</p>
<p>Нийслэлийн ЗДТГ, НМХГ-т явуулсан албан бичиг</p>	

2022.04.05-ны өдөр Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Төвийн бүсийн салбарын дарга Ж.Мөнхжаргал тэргүүтэй тус компанийн төлөөллийг хүлээн авч уулзлаа. Уулзалтад аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Я.Мөрөн нар оролцов. Мөн 2022.05.03-д Сүхбаатар сумын засаг дарга Т.Пүрэвсүрэнтэй тус тус уулзаж Сэлэнгэ аймгийн хамгаалалтын зурвасын 2003 оны захирамжийг шинэчлэх тухай албан бичиг өгч захирамжийг шинэчилсэн.

Говьсүмбэр аймгийн МХХ-ийн ажилтнуудтай уулзаж, цахилгаан дамжуулах агаарын шугамын хамгаалалтын зурваст газар олгохгүй байх талаар ярилцаж, зөрчлийг хамтран арилгаж ажиллах талаар тохиролцсон.

НАЙМ: ДҮГНЭЛТ

Эрчим хүчний хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “ЦДҮС” ТӨХК-ийн хэмжээнд 35, 110, 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудын “Хамгаалалтын зурвас”-ын дэглэм сахиулах ажлыг 2022 оны 03 дугаар сарын 14-нөөс 05 дүгээр сарын 16-ны хооронд хийж гүйцэтгэлээ. 2021 онд нийт **1299** айл өрх, аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэх хуудас, **АЛБАН ШААРДЛАГА** тараасан бол 2022 онд **1280** болж буурсан. 2021 онд мэдэгдэх хуудас тараах явцад **156** айл өрхийн гэр эзэнгүй, хашаа хаалга түгжээтэй байсан бол энэ онд **228** болж өссөн.



Компанийн хэмжээнд 2 сарын хугацаанд зохион байгуулагдсан “ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС АЯН”-ы хүрээнд бүх салбарууд төлөвлөгөө гаргаж батлуулан төлөвлөсөн ажлаа 100% амжилттай хийж гүйцэтгэлээ. Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрмийн хэрэгжилтийг хангах иргэн, аж ахуй нэгжийг дагаж мөрдүүлэх хяналт шалгалт зөрчил арилгах ажлуудыг зохион байгуулж машин механизмын болон хамгаалалтын зурваст газар шорооны ажил, хашаа барих ажилд хамгаалалтын зурвасын зөрчилтэй айл өрх, ААН-д мэдэгдэх хуудас тарааж шаардлага тавьсаны үр дүнд нийт **47** (Төвийн бүсийн салбарт **-25**, Зүүн-Өмнөд бүсийн салбарт **-3**, Улаанбаатар салбарт **-19**) зөрчлийг арилгуулж ажилласан. Хамгаалалтын зурвасын дагуу үзлэг хийхэд Сэлэнгэ аймагт – 3, Төв аймагт – 4, Говьсүмбэр аймаг **-1**, Булган аймагт **-6**, Хөвсгөл аймагт **-5** буюу нийт 19 айл өрх хамгаалалтын дэглэм зөрчиж шинээр нэмэгдсэн. Компанийн хэмжээнд 2022 оны 05 дугаар 15-ны байдлаар **960** айл өрх, **285** ААН хамгаалалтын зурвасын зөрчилтэй байна.

Хамгаалалтын зурвасын зөрчилтэй айл өрх ААН-ээр 2022 оны 03-05 дугаар саруудад бүрэн явж шинэчилсэн судалгааг багийн дарга, газрын даамал, орон нутгийн удирдлагын хамт шинэчлэн гаргасан ба Нийслэлийн Хан-Уул, Баянзүрх, Сонгино хайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн хамгаалалтын зөрчилтэй 995 айл өрхөд мэдэгдэх хуудас, Говьсүмбэр, Дархан-Уул аймгийн 32 айлд газрын албаны албан шаардлага, **28** ААН-д Улсын байцаагчийн албан шаардлагыг тус бүр биечлэн эзэмшигч бүрд өгч ажилласан. Мөн ЭХЯ, МХЕГ, НМХГ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Архангай, Төв, Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Дундговь

аймгуудын газрын албанд хамгаалалтын зурвасын зөрчилтэй ААН, айл өрхийн зөвшөөрлийг цуцлан цаашид зөрчил дахин гаргахгүй байх тал дээр хамтран ажиллах **30** гаруй албан бичиг (Төвийн бүсийн салбарт-5, Зүүн-Өмнөд бүсийн салбарт-8, Улаанбаатар салбарт-10, Говийн бүсийн салбарт-2, Хангайн бүсийн салбарт-6) төлөвлөж явуулсан. Сэлэнгэ аймгийн хамгаалалтын зурвасын захирамжийг шинэчлүүлэн авсан ба харьяа 220, 110кВ-ын АШ-ыг кадастерт оруулах ажлыг эхэлсэн. Ингэснээр Дархан-Уул болон Сэлэнгэ аймгийн 220 кВ, 110кВ-ын АШ, **16** дэд станцын хамгаалалтын зурвасыг кадастрийн зурагт оруулаад байна.

Дунговь аймгийн засаг дарга-д 2022 оны 3 дугаар сарын 22-ны өдөр Хамгаалалтын зурвас тогтоолгох талаар салбарын даргын 01/88 тоот албан бичгээр хүргүүлж 2022 оны 4-р сарын 5-ны өдрийн А/138 тоот захирамжаар хамгаалалтын зурвас тогтоолгох тухай захирамжийг гаргуулж аван мөрдөж ажиллаж байна.

Энэ аяны хүрээнд аймаг сумын засаг дарга, удирдлага, багын дарга, газрын албатай хамтран ажилласан нь үр дүнтэй байсан бөгөөд цаашид хамгаалалтын зурвасын зөрчлийг дахин нэмэгдүүлэхгүй байхаар анхаарч хамтын ажиллагааг улам дээшлүүлэхээр ажиллаж байна. Мөн сургалт сурталчилгааг таньж мэдүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын шторкын линкийг баг сум орон нутагт өгөхөөс гадна ашиглалтын инженерүүд орон нутгийн дотоод сайтуудад тавьж ажилласан.

Хамгаалалтын зурвасын зөрчил нь үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулж байгаа талаар сэрэмжлүүлэг мэдээллийг Монголын олон нийтийн үндэсний телевизийн “ЦАГИЙН ХҮРД” хөтөлбөр, ТВ-9 болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүрт гаргаж мэдээ мэдээллийг хүргэж ажилласан.

Ийнхүү ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС аяны хүрээнд зөрчилтэй айл өрхийн хаяг судалгааг шинэчлэн зурагжуулан гаргасан ба шаардлагатай захирамжийг орон нутгаар баталгаажуулсан, трасс болон дэд станцын цэвэрлэгээг цаг хугацаанд хийсэн зэрэг багагүй ажлыг бид хийж гүйцэтгэлээ.

ЕС. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

- Нийслэлийн Хот байгуулалтын хөгжлийн инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэстэй хамтран 220, 110, 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын шугам сүлжээний хамгаалалтын зурвасын мэдээлийн санд тулгалт хийж дутуу мэдээллийг шинэчлэн оруулах
- Алслагдсан ЦДАШ-ын тулгуурын хийц хэсгийг гэмтээх, хулгайлах зөрчлүүд гарч байгаатай холбогдуулан гэрээт эргүүл ажиллуулах.
- Салбаруудад 220/110 кВ-ын Цахилгаан дамжуулах агаарын шугамуудын үзлэгийн явцад илэрсэн хамгаалалтын зурвасын зөрчлийн талаар албан бичгийг төлөвлөж тухайн нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу аймаг, сумын засаг дарга, ойн ангийн дарга нарт хүргүүлэх, хяналт тавьж ажиллах,
- Шинээр ашиглалтад орсон их тойруугийн ЦДАШ-ууд харьяа дүүргийн газрын албанаас эзэмших, өмчлөх гэрчилгээтэй газраар баригдаж ашиглалтад оруулж байгаа нь шаардлага тавихад хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэдэг.
- ЦДАШ-ын хамгаалалтын зурвасын ойролцоох аж ахуй нэгжүүд өөрт олгосон газрын нэгж талбайгаа хэтрүүлж хашаа барьдаг хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байна.

ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ХЭЛТЭС

ХОЛБОГДОХ ЗУРАГ



ЭВТ ТӨМӨР ХХК зөрчил арилгах тухай албан бичгийг хүргүүлж буй байдал



АЛТАН ТАЙЖ ХХК зөрчил арилгах тухай албан бичгийг хүргүүлж буй байдал




Гурвалжингийн гүүрний баруун тал 109, 110 дугаар агаарын шугамын хамгаалалтын зурвасын хашааг засварлах үеийн зураг



Хамгаалалтын зөрчил арилгах тухай албан бичгийг хүргүүлж буй байдал



Хамгаалалтын зөрчил арилгах тухай албан бичгийг хүргүүлж буй байдал





Зөрчилтэй айл 1-р баг Барилгачин 3-16 тоот Ж.Банзрагч- дутуу татсан.



Хөтөл АШ Т№ 109-110 хооронд хашаа бүрэн орсон